



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 4-р сарын 3-аас
9-ны байдлаар

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 4-р сарын 3-9-ны байдлаар

COVID-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, Пандемик (цар тахал)-ын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулах зорилгоор улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутмын гадаад орчны тойм мэдээллийг бэлтгэн нийтэд мэдээлж байна. Энэхүү тоймын дөрөв дэх дугаарыг хүргэж байгааг хүлээн авна уу.

1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

Блүүмберг агентлагаас тооцсон “Global GDP tracker” индикатор энэ оны **3-р сард дэлхийн эдийн засаг агшсаныг илтгэж байна**. Тус индикаторын тооцоогоор дэлхийн эдийн засгийн жилийн өсөлт энэ оны эхэнд 4.2 хувь, 2-р сард 0.1 хувь байсан бол 3-р сард -0.5 хувь болов. Улс орнууд Ковид-19 цар тахлын тархалтыг хязгаарлах зорилгоор 3-р сараас эхлэн хөл хориог эрчимжүүлсэн нь эдийн засгийн үйл ажиллагааг хурдтай сааруулж байна. Дэлхийн томоохон эдийн засгуудад хөл хорио 4-р сард ч үргэлжлэх төлөвтэй байгаа тул дэлхийн эдийн засгийн уналт хараахан ёроолдоо хүрээгүй гэж Блүүмбергийн шинжээчид үзэж байна.

Азийн Хөгжлийн Банк 4-р сард нийтэлсэн “Азийн хөгжлийн төлөв 2020” тайландаа Ковид-19 цар тахлын эдийн засгийн үр нөлөөг хорио цээрийн үргэлжлэх хугацаанаас хамааруулан 2 хувилбараар тооцжээ. Үүнд **хөл хорио богино хугацаанд үргэлжлэх тохиолдолд Ковид-19 цар тахлын дэлхийн эдийн засгийн өсөлтөд -2.3 нэгж хувийн нөлөөтэй, харин хөл хорионы хугацаа сунжрах тохиолдолд -4.8 нэгж хувийн нөлөөтэй** гэж тооцсон байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Ковид-19-ийн дэлхийн болон Азийн бүс нутгийн эдийн засагт үзүүлэх нөлөө

Estimated global and regional impact of the COVID-19 outbreak, under different scenarios				
	Shorter containment, smaller demand shocks		Longer containment, larger demand shocks	
	% of GDP	Losses, \$ billion	% of GDP	Losses, \$ billion
World	-2.3	2,013.0	-4.8	4,090.8
People's Republic of China	-4.6	628.0	-5.1	691.6
Developing Asia excluding the PRC	-1.0	93.3	-2.2	200.1
Rest of the world	-2.0	1,291.6	-5.1	3,199.1

GDP = gross domestic product, PRC = People's Republic of China.
Source: ADB estimates.

Тус тайланд Азийн хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлт 2020 онд 2.2 хувь (үүнд Монголын эдийн засгийн өсөлт 2.1 хувь, БНХАУ-ын өсөлт 2.3 хувь)-д хүрч буураад 2021 онд эргэн сэргэнэ гэсэн төсөөллийг хийжээ.

- **Улс орнуудын ажилгүйдлийн түвшин нэмэгдсээр байна.** Тухайлбал, АНУ-ын ажилгүй иргэдийн тоо 3-р сард 7.1 саяд, ажилгүйдлийн түвшин 4.4 хувьд хүрлээ¹. Түүнчлэн зөвхөн сүүлийн 2 долоо хоногт 10 сая иргэн ажлаа алдаж бүртгүүлээд байгаа тул 4-р сард ажилгүйдлийн түвшин 2 оронтой тоонд хүрч болзошгүй байна.
- АНУ-ын Холбооны нөөцийн банк зах зээлийг тогтворжуулах, санхүүжилтийн нөхцөлийг зөөлрүүлэх бодлогын хүрээнд бондын худалдан авалтыг 3-р сард эрчимжүүлснээр 1.5 их наяд ам.доллараар нэмэгдэж, түүхэн дээд түвшинд буюу 5.8 их наяд ам.долларт хүрэв.
- Японы Засгийн газар түүхэнд байгаагүй өндөр дүнтэй буюу 989 тэрбум ам.доллар (ДНБ-ний 20%)-тай тэнцэх хэмжээний эдийн засгийг дэмжих багц баталж, хэрэгжүүлэхээр зарлав. Тус багц арга хэмжээний хүрээнд бага орлоготой өрхүүдэд 300 мянган иен буюу 2800 орчим ам.долларын мөнгөн туслалцаа үзүүлнэ. Дэлхийн 3 дахь том эдийн засагт коронавирусийн халдвар нэмэгдэж байгаатай холбогдуулан Ерөнхий сайд Шинзо Абе 1 сарын хугацаатай онц байдал зарлаж, хүн амын төвлөрөл их, вирус тархах эрсдэл өндөртэй Токио Осака зэрэг 7 хот, бүсэд хэрэгжүүлэхээр болов.
- Их Британид сүүлийн 2 долоо хоногт 1 сая иргэн ажилгүйдлийн тэтгэмж авсан нь жирийн үеэс 10 дахин өндөр байв. Английн төв банк түр хугацаанд Ковид-19 цар тахлын үеийн Засгийн газрын зайлшгүй зардлыг санхүүжүүлэх төлөвтэй байна.
- Тайлант хугацаанд Евро бүсийн сангийн сайдууд 500 тэрбум еврогийн эдийн засгийг дэмжих багцыг батлах хүлээлттэй байсан ч, хараахан баталж чадсангүй. 2 дахь шатны яриа хэлэлцээр хийгдэхээр хүлээгдэж байна.
- “IGM Economic Experts Panel”- шилдэг эдийн засагчид, шинжээчдийн дунд “Халдвар дахин сэргэх магадлал өндөр хэвээр байгаа энэ үед хөл хориог сулруулах нь эдийн засагт илүү их хохирлыг авчрах уу?” гэсэн санал асуулгад АНУ-ын эдийн засагчдын 80% нь санал нэгдсэн бол Европын шинжээчдийн 65% нь санал нэгджээ.
- ОХУ газрын тосны үйлдвэрлэлээ өдөрт 1.6 сая баррель буюу 15%-иар бууруулахаар болж байгаа мэдээ гарснаар газрын тосны үнэ өснө гэсэн хүлээлтийг нэмэгдүүлэв. Газрын тосны үнэ ОХУ-ын төсөвт тооцсон 1 тонн нь 42 ам.доллар гэсэн түвшнээс доош унаад байгаа нь төсвийн орлого, рублийн ханшид сөргөөр нөлөөлсөөр байна.

¹ Энэ нь 2017 оны 8 сараас хойшхи хамгийн өндөр ажилгүйдлийн түвшин юм.

2 ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- **Хятадын эдийн засаг** энэ оны 2-р сарын эцэст 60-70 хувийн, 3-р сарын 27-ны байдлаар 90 хувийн, **4-р сарын 3-ны байдлаар 90-95 хувийн потенциалгаар ажиллаж байна**². Энэ оны 3-р сарын эцэст Хятадын томоохон аж ахуй нэгж, компаниудын 98.6 хувь, жижиг аж ахуй нэгжүүдийн 76.8 хувь нь үйл ажиллагаагаа сэргээсэн бөгөөд нийт ажилчдын 90 хувь нь ажилдаа эргэн орлоо³. Харин үл хөдлөх хөрөнгийн салбар харахан сэргээгүй байна. Хятадын 1-р зэрэглэлийн хотууд (Бээжин, Шанхай, Гуангжоу) дахь үл хөдлөх хөрөнгийн борлуулалт 3-р сарын 27-ны байдлаар 358,000 метр² хүрч 1-р сарын түвшний дөнгөж 36 хувьтай тэнцэж байна.
- Ковид-19 өвчлөлөөс шалтгаалан эрэлт төдийлөн сайжрахааргүй байгаа тул **коксжих нүүрсний дэлхийн зах зээл дээрх үнэ болон Хятадын эрчим хүчний нүүрсний үнэ 5 дахь долоо хоногтоо буурч байгааг SXCoal 4-р сарын 8-ны өдрийн тоймдоо мэдээлэв.** Тухайлбал, SXCoal-ийн судалгаанд оролцсон коксжих нүүрсний уурхайнуудын хүчин чадал 3-р сарын 26-наас 4-р сарын 2-ны хооронд өмнөх долоо хоногоос 0.75 нэгж хувиар буурч 114.2 болов. Түүнчлэн, түүхий болон угаасан нүүрсний нөөц өмнөх долоо хоногийн түвшнээс 9.1 хувь болон 14.6 хувиар тус тус нэмэгдсэнээр 5 дахь долоо хоногтоо нөөц нэмэгдэв. 2-р улиралд дэд бүтцийн төслүүд эхэлснээр, гангийн эрэлт нэмэгдэж жилийн үйлдвэрлэл өмнөх оны түвшинд байх хүлээлттэй байна.
- **Хятадын төсвийн бодлого:** Ковид-19 өвчлөлтэй холбоотойгоор татварын хөнгөлөлт, нийгмийн халамжийн бодлогоос гадна тусгай зориулалттай бондын хэмжээ нэмэгдсэнээр 2019 онд ДНБ-ийн 5 хувь байсан төсвийн алдагдал 2020 онд 6.4 хувь буюу түүхэн дээд хэмжээнд хүрэхээр байгааг Блүүмбергийн шинжээчид 4-р сарын 6-нд мэдээлэв. Харин Хятадын Засгийн газраас нэмэлт төсвийн дэмжлэг зарлах тохиолдолд төсвийн алдагдал 2020 онд ДНБ-ий 9.5 хувьд хүрч нэмэгдэхээр байна. Ковид-19 өвчлөлийн эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулж, дотоод эрэлтийг дэмжих татварын хөнгөлөлтүүд болон нийгмийн халамжийн бодлогын хүрээнд төсвийн орлого 900 тэрбум юань (ДНБ-ий 0.8 хувь)-тай тэнцэх хэмжээгээр тасрахаар байна. Өвчлөлтэй холбоотойгоор нийгмийн халамжийн зардал болон ажилгүйдлийн тэтгэмж нэмэгдсэнээр төсвийн зардал жилийн туршид ДНБ-ий 0.25 хувьтай тэнцэх хэмжээгээр нэмэгдэх төлөвтэй. Одоогоор зарлагдаад байгаа боломжит мэдээллээр төсвийн нийт дэмжлэг 2020 онд 3 их наяд юань (ДНБ-ий 3 хувь)-д хүрэх боломжтой юм.
- Хятадын худалдааны гол түнш орнуудад Ковид-19 цар тахлын тархалт эрчимтэйгээр нэмэгдсээр байгаа нь Хятадын **экспорт оны эхний 2 сард 17.2 хувиар буурахад нөлөөлсөн бол 3-р сард мөн ижил тренд ажиглагджээ.** Эдийн засаг нь 90-95 хувийн потенциалгаар ажиллаж байгаа хэдий ч, өрхийн орлого буурсан тул бизнесийн идэвхжил, дотоод эрэлт төдийлөн нэмэгдээгүй

² Блүүмбергийн шинжээчдийн тооцоолол. Үүнд тооцоололд вирусийн голомт Хубэй муж ороогүй болно.

³ Хятадын Аж үйлдвэр, мэдээлэл технологийн яамны мэдэгдэл

байгаа. Хятадын Төрийн зөвлөлийн хурлын мэдэгдэлд дэвшүүлсэн “2020 онд 2010 оны ДНБ-ий түвшинг 2 дахин нэмэгдүүлэх” зорилт өөрчлөгдөөгүй, хэвээр байгаа бөгөөд өрхийн хэрэглээг эргэн нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт, барилгын салбар дахь аж ахуй нэгжүүдийг үйл ажиллагааны хурдцыг ахиулах арга хэмжээний чиглэл өгчээ.


- **Хятадын мөнгөний бодлого:** Хятадын Ардын Банк 4-р сарын 3-нд жижиг банкуудын заавал байлгах нөөц (ЗБН)-ийн хувийг 1 нэгж хувиар буурууллаа. Мөн хүүний коридорын доод утгыг⁴ 0.72 хувиас 0.35 хувь хүргэн бууруулсан нь 2008 оны хямралаас хойшхи анхны тохиолдол болов. ЗБН-ийн хэмжээг үе шаттайгаар бууруулж, нийт 400 тэрбум юанийг чөлөөлөх, бодлогын хүүг бууруулах хүлээлт хэвээр байна.

3 МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ


Гадаад худалдааны эргэлт буурч, тэнцэл алдагдалтай гарлаа. 2020 оны эхний 3 сарын байдлаар гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 860 сая ам.доллар (28%-аар буурсан бол экспорт 736 сая ам.доллар (42%-аар, импорт 124 сая ам.доллар (10%-аар тус тус буурлаа (Зураг 1). Зөвхөн 3 дугаар

сард экспорт өмнөх сараас 46.6 сая ам.доллар (15%-аар буурсан бол импорт 134.8 сая ам.доллар (49%-аар өсөв. Өнгөрсөн хугацаанд түүхий эдийн үнийн уналт болон боомтын хязгаарлалтаас хамаарч экспортын орлого багассан нь гадаад худалдааны тэнцэл 125.7 сая ам.долларын алдагдалтай гарахад нөлөөлсөн.

Зураг 1. Экспорт, импорт болон худалдааны эргэлтийн өсөлт, сараар



Зураг 2. Экспорт, импорт, тухайн сараар



Эх сурвалж: Монголбанк

⁴ IOER-cut the bottom of its “interest rate corridor”

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө биелсэн боловч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.8% буурсан байна. 2020 оны 2 дугаар сарын төсвийн гүйцэтгэлээр тэнцвэржүүлсэн нийт орлого 1369.3 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 2.6%-иар буюу 34.5 тэрбум төгрөгөөр давж биеллээ. Үүнээс татварын орлогын дэлгэрэнгүй задаргааг авч үзэхэд 2020 оны 2 дугаар сард нийт 598.9 тэрбум төгрөгийн татварын орлого бүрдсэний 36% (215.5 тэрбум төгрөг) нь ААНОАТ, 12% (74.3 тэрбум төгрөг) нь ХХОАТ, 26% (155.0 тэрбум төгрөг) нь НДШ байгаа бол


ердөө 1 орчим хувь (3.7 тэрбум төгрөг) нь НӨАТ-ын орлого байна. НӨАТ-ын орлого өмнөх оны мөн үеэс **97.6% буюу 147.8 тэрбум** төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь бизнесийн идэвхжил буурч байгааг илтгэж байна.

Харин төсвийн нийт зардал өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 29.2%-аар нэмэгдсэн буюу урсгал зардал 14.6%, хөрөнгийн зардал 203.3% -аар тус тус өсчээ.

Хүснэгт 2. Тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн, эхний 2 сар


	Төсөв	Гүйцэтгэл	Хувь-1	Зөрүү
Татварын орлого	1,186,526.8	1,255,245.0	105.8%	68,718.2
Татварын бус орлого	148,508.2	114,043.0	76.8%	-34,465.2
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	1,335,035.0	1,369,288.0	102.6%	34,253.0

Татварын орлогын задаргаа:



Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк

Зураг 3. Инфляц, сараар



Эх сурвалж: Монголбанк


Эдийн засаг, бизнесийн идэвхжил саарсан хэдий ч, нийлүүлэлтээс шалтгаалсан инфляц бага зэрэг өсөв.

Жилийн инфляц 3 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 6.4%, Улаанбаатар хотын хэмжээнд 6.8% байна. Эдийн засгийн идэвхжил, ерөнхий төлөв саарах хандлагатай байгаа хэдий ч, иргэд, ААН-үүд нийлүүлэлтийн хомстол үүсэх эрсдэлээс сэргийлж худалдан авалтаа нэмэгдүүлэх хандлагатай байгаа нь богино хугацаанд инфляц бага зэрэг өсөхөд нөлөөлж байна (Зураг 3).

Эдийн засгийн зогсонги байдлаас үүдэн Монголын хөрөнгийн захын идэвхжилийн бууралт үргэлжилж байна. 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр I, II, III ангиллын 21 хувьцаат компанийн 36,5 сая төгрөгийн үнийн дүн бүхий 374,732 ширхэг хувьцаа арилжигдсанаас 7 хувьцаат компанийн хувьцааны ханш өсч, 13 хувьцаат компанийн хувьцааны ханш буурсан бол 1 үнэт цаасны ханш тогтвортой байлаа байна. Улмаар ТОП-20 индексийн үзүүлэлт 16,791 болж оны эхнээс 13%-иар буураад байна.

Дэлхийн санхүүгийн зах зээлд Ковид-19 цар тахлаас үүдэлтэй эрсдэл,


Зураг 4 Хөрөнгийн биржийн Тор-20 индекс



Банкуудын зээлийн үлдэгдлээс харахад Ковид-19-ийн эсрэг арга хэмжээ авч эхэлсэн 2-р сараас хойш зээлийн чанар муудсан байна. 2020 оны эхний сард үйл ажиллагаа явуулж буй 13 банкны нийт зээлийн 86.5%-ийг хэвийн зээл, 5.2%-ийг хугацаа хэтэрсэн зээл, 8.3%-ийг чанаргүй зээл бүрдүүлж байсан бол 4 дүгээр сарын 5-ны

тодорхойгүй байдал нэмэгдсэнээр голлох хөрөнгийн биржийн индексүүд сүүлийн 1 сарын хугацаанд ойролцоогоор 25%-иар уналаа. Хөрөнгө оруулагчид эрсдэлтэй багцаа зарж (sell off) илүү хөрвөх чадвар өндөртэй хөрөнгөд эх үүсвэрээ байршуулж эхэлснээр **Монгол Улсын Засгийн газар болон компаниудын бондуудын үнэ унаж**, хүү нь 2020 оны 3 дугаар сараас эхлэн огцом өслөө. Хэрэв дэлхийн санхүүгийн зах зээлийн тогтворгүй байдал даамжирвал Монгол Улсын дахин санхүүжилтийн өртөг нэмэгдэх эрсдэлтэй байна (Зураг 7).

Зураг 5. МУ-ын бондуудын өгөөж (%)




Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж, Монголбанк тайлангаас харахад нийт зээлийн 84.4%-ийг хэвийн зээл, 7.8%-ийг хугацаа хэтэрсэн зээл, 7.8%-ийг чанаргүй зээл бүрдүүлсэн байна. Энэ нь зээлийн чанар муудсан буюу 1-р сартай харьцуулахад нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хэмжээ 2.1% буурч, хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ 2.6%-иар өсөөд байна.

2020 он гарсаар тэтгэврийн зээлээс бусад зээлийн шинээр олгосон дүн болон эргэн төлөлтийн хэмжээ буурсан байна⁵. 2019 оны 12 дугаар сард нийт зээлийн үлдэгдэл (тэтгэврийн зээл хассан)-ийн 11.4% буюу 1.97 их наяд төгрөгийн зээлийг эргэн төлсөн байна. Харин 2020 оны 2 дугаар сард энэ үзүүлэлт нь 8.3% болж буурчээ.

Зээл олголтын хэмжээ 2019 оны 12 дугаар сард 1.99 их наяд төгрөг байсан бол 2 дугаар сард 1.29 их наяд төгрөг болж 35%-иар буурсан байна. Үүнээс иргэдийн зээл 26%-иар, ЖДҮ эрхлэгч ААН-үүдийн зээл 39%-иар буурчээ (Зураг 9).

Зураг 4. Зээлийн эргэн төлөлт, тэтгэврийн зээлийг хассан /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Монголбанк

4 МОНГОЛ УЛСЫН АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ АРГА ХЭМЖЭЭ

2020 оны 3-р сарын 11-ний өдөр Мөнгөний бодлогын хорооноос санхүүгийн зуучлалыг дэмжих, банкуудын санхүүжилтийн эх үүсвэрийн өртгийг бууруулах, эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх зорилгоор (1) бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулах, (2) төгрөгийн заавал байлгах нөөцийн хувийг 2 нэгж хувиар бууруулж, 324 тэрбум төгрөгийн эх үүсвэр чөлөөлөх, (3) бодлогын хүүний коридорыг бодлогын хүүнээс +/-1 нэгж хувиар шинэчлэн тогтоох багц шийдвэр гаргасан.

Харин 3-р сарын 18-ны өдөр банкны “Активыг ангилах, активын эрсдэлийн

сан байгуулж, зарцуулах журам” болон “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д түр хугацааны өөрчлөлт орууллаа. Ингэснээр иргэнд олгосон зээлд тогтоох хугацааны ангиллыг “Хэвийн” зээлийн хувьд 15 хүртэлх хоног байсныг 90 хүртэлх хоног болгож уртасгаж, хэрэглээний болон бизнесийн зээлийн гэрээнд бүтцийн өөрчлөлт хийхэд ангиллыг бууруулахгүй боломжийг бий болголоо.

Түүнчлэн, 3-р сарын 20-ны өдөр банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжихэд чиглэсэн арга

нэмэгдсэн тул тэтгэврийн зээлийг хасаж тооцоолов.

⁵ МУ-ын Засгийн газраас тэтгэврийн зээлийг тэглэсэнтэй холбоотойгоор зээлийн эргэн төлөлтийн хэмжээ 2020 оны 2, 3 дугаар саруудад

хэмжээ авч Төв банкнаас арилжааны банкуудад олгох барьцаат зээлийн журамд өөрчлөлт оруулав. Ингэснээр банкууд барьцааны нөхцөл, шаардлагыг хангаснаар Монголбанкнаас 6 сарын хугацаатай (дахин 6 сараар сунгагдах боломжтой) эх үүсвэрийг 11 хувийн хүүтэй авч, төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа хангах боломжийг бүрдүүлэв.

4-р сарын 1-ний өдрөөс эхлэн COVID-19 вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор Монголбанк санаачлан гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд арилжааны банк хоорондын бага дүнтэй гүйлгээний шимтгэлийг дийлэнх банканд 20%, зарим банк 100% болгож бууруулахаар боллоо.

Төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээл авсан иргэдийг хамруулах зорилгоор Монголбанк, Сангийн яам, Монголын Ипотекийн Корпораци ОССК ХХК болон банкууд хамтран дараах шийдвэрийг гаргалаа. Үүнд:

- Орон сууцны ипотекийн 8 эсхүл 5 хувийн хүүтэй зээл авсан иргэн зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулах хүсэлт гаргасан тохиолдолд зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг нэг удаа 3 хүртэлх сараар хойшлуулж, тухайн хугацаагаар зээлийн эргэн төлөлтийн хуваарийг уртасгах;
- Зээлийн эргэн төлөлтөд нь 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрөөс хойш доголдол үүссэн зээлдэгчид энэхүү зохицуулалт үйлчлэх боломжтой бөгөөд доголдол үүссэн хуваарьт өдрөөс эхлэн эргэн төлөлтийг хойшлуулах хугацааг тооцох;

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 4 дүгээр сарын 13-ны

өдрийн ээлжит бус хурлаар Эдийн засаг, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв болон гадаад, дотоод орчны тодорхой бус байдал, эрсдэлийг харгалзан үзээд 1) бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж 9 хувьд хүргэх, 2) эргэн төлөлт нь хүндрэлд орсон зээлдэгчийн хэрэглээний зээлийн хугацааг 12 хүртэлх сараар сунгах шийдвэр гаргалаа. Энэ удаагийн шийдвэр нь инфляцийн зорилтыг алдагдуулахгүйгээр эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хадгалахад дэмжлэг болно.

Эдгээр Монголбанкнаас хэрэгжүүлж буй мөнгөний бодлогын төлөвийг зөөлрүүлэх, банкны зохицуулалтыг түр хугацаанд зөөлрүүлэх, банкны төлбөрийн чадварыг дэмжихэд чиглэсэн бодлогын багц арга хэмжээ нь санхүүгийн зуучлал хэвийн үргэлжлэх боломжийг бүрдүүлээд зогсохгүй COVID-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засагт учрах сөрөг нөлөөг бууруулахад чухал нөлөөтэй.

УИХ-ын дарга Г.Занданшатар 4-р сарын 10-ны өдөр Коронавируст халдварын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эдийн засгийг идэвхжүүлэх зорилгоор нефтийн бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх, орон сууцны ипотекийн санхүүжилтийг олгох, зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, зээлийн хүү, эх үүсвэрийн зардлыг бууруулах, банкны салбарын шинэчлэлийг эрчимжүүлэх, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг багтаасан УИХ-аас гаргахаар төлөвлөж буй тогтоолын төслийн талаар мэдээлэл өгөв. Энэхүү УИХ-ын тогтоолын хэлэлцүүлэг 4-р сарын 16-наас эхлэхээр хүлээгдэж байна.

Зураг 5. “Ковид-19”-н тархалт болон МУ-ын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

“COVID-19” ВИРУСЫН ТАРХАЛТ

МОНГОЛ УЛСЫН АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

2020.01.09
ДЭМБ шинэ коронавирусын анхны тохиолдлыг зарлав
ДЭМБ шалтгаан тодорхойгүй уушгины хатгалгаа шинэ төрлийн Коронавирусээр үүсгэгдсэн болохыг зарлав.

2020.01.13
Хятадаас бусад оронд тархаж эхлэв
Тайланд улсад анхны “Covid-19”-н тохиолдол бүртгэгдлээ. Үүний дараагаар Япон, АНУ, Солонгос зэрэг орнуудад бүртгэгдэв

2020.01.30
Хүнээс хүнд халдварласан нь тогтоогдов
Хүнээс хүнд халдварласан анхны тохиолдол бүртгэгдлээ. Хятад улстай ойролцоох улсуудад тархав

2020.02.22
Солонгос улсад тархалт нэмэгдэв
БНСУ-д “Covid-19” вирусээр халдварлагдсан тоо огцом өсөж эхлэв.

2020.03.03
Европ тивд тархалт нэмэгдэв
Хятад, Япон, Солонгост тархалт буурах хандлагатай байгаа боловч Европ тивд голмтлон тархаж эхлэв. Итали, Иран, Герман, Франц болон АНУ-д өвчлөлийн тархалт нэмэгдэж эхлэв.

2020.03.10
“Covid-19” вирус анхны тохиолдол Монголд бүртгэгдэв.
Монголд ирсэн Францын иргэнээс Covid-19 илрэв.

2020.03.11
“Covid-19”-г пандемик гэж зарлав.
Энэхүү тахлын аюул, цар хүрээ улам бүр ихсэж дэлхийн хэмжээнд нүүрлэсэн тул Дэлхийн эрүүл мэндийн байгууллага “Covid-19” вирусийн халдварыг дэлхийн хэмжээний пандемик буюу цар тахал гэж зарлав.

2020.03.16
МУ-ын 3 иргэнээс “Covid-19” илрэв.
Тусгай үүргийн онгоцоор ирж тусгаарлагдсан иргэдийн 3-аас нь “Covid-19” вирус анхны халдвар илрэв.

2020.03.17
МУ-д “Covid-19”-ын 5 дахь тохиолдол бүртгэгдэв.
Берлин-Москва-Улаанбаатар чиглэлийн тусгай үүргийн онгоцоор ирж, тусгаарлагдсан иргэнээс Covid-19 илрэв.

2020.03.19
МУ-д “Covid-19”-н 6 дахь тохиолдол бүртгэгдэв.
3-р сарын 16-нд Берлиний тусгай үүргийн онгоцоор ирсэн 1 иргэнээс Covid-19 илрэв.

2020.03.21
МУ-д “Covid-19”-н нийт 10 тохиолдол бүртгэгдэв.
ХБНГУ-аас гуравдугаар сарын 16-нд тусгай үүргийн онгоцоор ирсэн 4 хүнээс Covid-19 илэрсэн болохыг ЭМЯ-аас мэдээлэв.

2020.03.26
МУ-д “Covid-19”-н 11 дэхь тохиолдол бүртгэгдэв.
3-р сарын 18-ны Истанбулын тусгай үүргийн онгоцоор ирсэн 1 иргэнээс Covid-19 илрэв.

2020.03.28
МУ-д “Covid-19”-н 12 дэхь тохиолдол бүртгэгдэв.
3-р сарын 18-ны Истанбулын тусгай үүргийн онгоцоор ирсэн дахин 1 иргэнээс Covid-19 илрэв.

2020.03.30
Covid-19 халдвар авсан 2 авчтөн эрүүлжиж, эмнэлэгээс гарав
Халдвар авсан 2 өвчтөнд илрэх өвчний шинж тэмдгүүд бүрэн арилсан тул эмнэлэгээс гаргав.

2020.04.01
МУ-д “Covid-19”-н 13, 14 дэхь тохиолдол бүртгэгдэв.
3-р сарын 28-ны Солонгосын тусгай үүргийн онгоцоор ирсэн Туркийн ЭСЯ-ны ажилтны ар гэрийн гурван хүн ирсний хоёроос нь коронавирус илэрлээ

2020.04.06
МУ-д “Covid-19”-н 15 дэхь тохиолдол бүртгэгдэв.
ХӨСҮТ-д тусгаарлагдан, хянагдаж байсан Туркийн нэг иргэний шинжилгээнээс коронавирус илэрлээ

2020.04.07
Covid-19 халдвар авсан дахин 2 авчтөн эрүүлжиж, эмнэлэгээс гарав
Халдвар авсан 2 өвчтөнд илрэх өвчний шинж тэмдгүүд бүрэн арилсан тул эмнэлэгээс гаргав.

2020.04.08
МУ-д “Covid-19”-н 16 дэхь тохиолдол бүртгэгдэв.
ОХУ-н хилээр 2020 оны гуравдугаар сарын 26-27-нд шилжих шөнө орж ирсэн иргэний давтан шинжилгээнээс коронавирус илэрлээ.



2020.01.24

Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр зогсоов
Бүх түвшний сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа болон олон нийтийг хамарсан арга хэмжээг түр зогсоох шийдвэр гаргав.

2020.02.10

Хилийн боомтуудыг түр хаав
Монгол, Хятадын хилийн боомтуудаар нэвтрэх нүүрс тээвэрлэлт болон иргэдийн хөдөлгөөнд түр хязгаарлалт хийв.

2020.02.12

Өндөржүүлсэн бэлэн байдал зарлав
Өндөржүүлсэн бэлэн байдлыг хэсэгчилсэн байдлаар зарлаж цагаан сарын баяр тэмдэглэхийг хориглов.
2020.02.20: Улс, хот хоорондын хөдөлгөөнийг 2-р сарын 23-27-ны хооронд түр зогсоох шийдвэр гаргав.

2020.02.27

МУ-ын Ерөнхийлөгч БНХАУ-д айлчлав.
Зарим үйлчилгээний газруудын үйл ажиллагааг түр зогсоов
• Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бүх төрлийн баар, спорт, шашин, урлаг соёлын газар болон амралт, жуулчны бааз, дэн буудлын үйл ажиллагааг 3-р сарын 30-ны өдрийг дуустал түр зогсоов.
• Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэн үед эдийн засгаа дэмжих бодлогын талаар тогтоол гаргав

2020.02.28

Түрээсийн төлбөрөө бууруулбал татвараас чөлөөлнө
Өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд төвлөрсөн зах худалдааны төв, үйлчилгээний газруудад худалдаа үйлчилгээний чиглэлээр татвар төлөгчийн түрээсийг нэг удаа чөлөөлөх хуулийг УИХ-д өргөн мэдүүлнэ. Гэхдээ түрээсийн төлбөрөө бууруулсан тохиолдолд үйлчлэх боломжтой.

2020.03.10

• Хот хоорондын зорчих хөдөлгөөнийг 3-р сарын 16-ны өдөр хүртэл түр зогсоов.
• Жирэмсэн болон 0-12 насны хүүхэдтэй эмэгтэй ажилтан, албан хаагчийг гэрээсээ ажиллах нөхцөл боломжоор хангах, цалинтай чөлөө олгох зэрэг арга хэмжээ авч ажиллахыг чиглэл болгов.

2020.03.11

Бодлогын хүүг бууруулав
Мөнгөний бодлогын хороо бодлогын хүүг 1 нэгж, банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2 нэгж хувиар бууруулах болон бодлогын хүүний коридорыг бодлогын хүүнээс +1,-1 нэгж хувийн өргөнтэй болгон өөрчлөх шийдвэр гаргав.

2020.03.18

Зээлийн ангилал, эргэн төлөлтөд өөрчлөлт оруулав
Монголбанкнаас зээлдэгч нь зээлийн төлбөрөө түр хугацаагаар төлөх боломжгүй тохиолдолд тухайн зээлдэгчийг Зээлийн мэдээллийн санд ангилал бууруулж мэдээлэхгүй байх боломжийг бүрдүүлэв.

2020.03.23

6 сар хүртэлх санхүүжилтийн эх үүсвэрийг банкуудад олгохоор шийдвэрлэв.
Төв банкнаас банкны салбарын хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор дотоод журмууддаа өөрчлөлт оруулж 6 сар хүртэлх санхүүжилтийн эх үүсвэрийг банкуудад олгохоор зохицууллаа. Энэ нь санхүүжилтын зардлыг бууруулах зорилготой юм.

2020.03.27

Засгийн газраас эдийн засгийг дэмжих дараах 7 шийдвэр гаргав
• 2020 оны 04.01-10.01 хүртэл ААН-үүдийг НДШ-ээс чөлөөлөх;
• 2020 оны 04.01-10.01 хүртэл цалинд ХХОАТ ногдуулахгүй байх;
• 2020 оны 04.01-10.01 хүртэл албан татвар төлөгчдийг ААНОАТ-аас чөлөөлөх;
• COVID-19-тэй холбоотойгоор ү/а нь доголдонд ч ажлын байраа хадгалсан ААН-үүдийн ажилтан бүрт сар бүр 200,000₮-н бэлэн мөнгөний дэмжлэг 3 сар олгох;
• Малчдын амьжиргааг дэмжих зорилгоор ноолуур худалдан авагч, бэлтгэгчдэд 3%-н хүүтэй нэн хөнгөлөлттэй зээл олгох;
• Хүүхдийн мөнгийг гурван сар 10,000 төгрөгөөр нэмэгдүүлж олгох;
• 2020.04.15-аас шатахууныг литр тутамд 300, түүнээс дээш төгрөгөөр бууруулах.

2020.03.31

Бага дүнтэй гүйлгээний шимтгэлийг буурууллаа
Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд банк хоорондын бага дүнтэй гүйлгээний шимтгэлийг 20-100 хувь бууруулахаар боллоо.

2020.04.03

Төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээлийн эргэн төлөлтийг түр хугацаагаар хойшлууллаа
Орон сууцны ипотекийн 8 эсхүл 5 хувийн хүүтэй зээл авсан иргэн зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулах хүсэлт гаргасан тохиолдолд зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг нэг удаа 3 хүртэлх сараар хойшлуулах;
2020.04.03

2020.04.03

Дэлхийн банкнаас олгох 26.9 сая ам.долларын санхүүжилтийн хэлэлцээрт гарын үсэг зурлаа
Нэн шаардлагатай байгаа эмнэлгийн тоног, төхөөрөмж, багаж хэрэгсэл нийлүүлэх Дэлхийн банкны 26.9 сая ам.долларын “Коронавирус халдвараас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төслийн санхүүжилтийн хэлэлцээрт өнөөдөр гарын үсэг зурлаа.

2020.04.10

Ипотекийн зээлийн төлөлтийг хойшлуулах хугацааг дахин 3 сараар сунгаж, 6 сар болголоо


5 ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭД ҮЗҮҮЛЖ БҮЙ НӨЛӨӨ

Манай улсын экспортын гол эрдэс бүтээгдэхүүнүүдийн үнэ өнгөрсөн 7 хоногт харьцангуй өссөн үзүүлэлттэй байлаа. Тухайлбал, сүүлийн 18 жилийн хамгийн доод түвшинд хүрээд байсан газрын тосны үнэ ОХУ, Саудын Араб улсууд гарцаа танах хэлэлцээртэй зэрэгцэн 40 хувиар өсч 32.8 ам.долларт хүрэв. Мөн алт болон зэсийн ханш 5 орчим хувиар өссөн бол 3-р сард харьцангуй тогтвортой, өндөр түвшинд байсан төмрийн хүдрийн үнэ буурав.


Газрын тосны үнэ. 2020 оны эхэнд АНУ, Ираны зөрчлийн улмаас Brent төрлийн газрын тосны ханш 70 орчим ам.долларт хүрч байв. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс өндөр дүн байв. Дэлхийн хамгийн том газрын тос импортлогч, нийт эрэлтийн тэн хагасыг бий болгодог Хятад улсад шинэ вирус дэгдсэнтэй холбоотойгоор газрын тосны үнэ унаж эхэлсэн. Вирусийн халдвар олон оронд эрчимтэй тархаж, улс орнууд хилийн хориг, хариу арга хэмжээ авснаар дэлхийн аялал жуулчлал, тээврийн салбарын үйл ажиллагаа хумигдаж, үүнийг дагаад түлш, шатахууны эрэлт буурч байна. Нөгөө талд, томоохон газрын тос нийлүүлэгч ОХУ, Саудын Араб зэрэг улсууд үйлдвэрлэлээ

нэмэгдүүлэх шийдвэр гаргасны улмаас дэлхийн зах зээл дээр газрын тосны илүүдэл үүсэж, 3 дугаар сард газрын тосны үнэ тасралтгүй унасаар 2002 оноос хойшхи хамгийн доод түвшин буюу 22.7 ам.долларт хүрсэн. Харин ОХУ газрын тосны гарцаа танах хүлээлттэй холбоотойгоор өнгөрсөн долоон хоногт газрын тосны үнэ буцаж өсөн 32.8 ам.долларт хүрэв. 4-р сарын 9-нд ОХУ, Саудын Араб, ОПЕК-ийн гол улсуудын хооронд болсон онлайн хурлаар газрын тосны үйлдвэрлэлийг хоногт 10 сая баррелиар бууруулах шийдвэрт хүрсэн байна. Энэхүү шийдвэр нь газрын тосны үнэ цаашид өсөх хүлээлтийг бий болгож байна.

Зураг 11. Газрын тосны үнэ



Зураг 12. Зэсийн үнэ



Эх сурвалж: www.investing.com

Зэсийн үнэ. Ковид-19 нь Хятадаас гадна олон улсад эрчимтэй тархаж, дэлхийн эдийн засагт тодорхойгүй байдал, эрсдэл бий болгосонтой холбоотойгоор зэсийн ханш огцом унаж эхэлсэн. 3 дугаар сарын 23-ны байдлаар 4,609 ам.долларт


хүрч унасан. Харин сүүлийн 2 долоо хоногийн хугацаанд зэсийн үнэ буцаж сэргэн 5,021 ам долларт хүрлээ. 2019 оны эхний улиралд зэсийн ханш өсөх хандлагатай байсан бөгөөд оны эхнээс

10 гаруй хувиар чангарч 6500 орчим ам.долларт хүрч байжээ.


Алтны хани. Энэ оны эхэнд үүссэн АНУ болон Ираны харилцаанаас үүдэн алтны ханш 1,500-аас 1,580 ам.долларт хүрэв. Харин шинэ вирусийн халдвар дэлхийн олон оронд тархаж эхэлсэнтэй зэрэгцээд алтны ханш ихээхэн хэлбэлзэж 3 дугаар сарын эхээр 2012 оноос хойших хамгийн дээд түвшин буюу унц нь 1,700 орчим ам.долларт хүрсэн. 3 дугаар сарын дунд үеэс ихэнх

хөгжилтэй улсуудын засгийн газар, төв банкууд Ковид-19-ийн сөрөг үр нөлөөг бууруулах, эдийн засгаа дэмжих арга хэмжээг шийдэмгий авч байгаагийн улмаас алтны ханш огцом буурч 1,500 орчим ам.долларт хүрсэн. Гэвч сүүлийн 2 долоон хоногт АНУ болон зарим улсад вирусийн тархалт эрчимтэй нэмэгдсэнээр алтны ханш буцаж сэргэн 1,700 орчим ам.долларт хүрээд байна. Энэ нь 2019 оны мөн үетэй харьцуулахад 25 хувиар буюу 350 ам.доллараар өндөр ханштай байна.

Зураг 13. Алтны хани



Зураг 14. Төмрийн хүдрийн үнэ



Эх сурвалж: www.investing.com

Төмрийн хүдрийн үнэ. 2019 оны 11 сарын эхэнд 80 ам.долларт хүрч байсан төмрийн хүдрийн ханш тасралтгүй өссөөр 2020 оны эхний сард 95 ам.долларт хүрсэн байна. 2 дугаар сарын эхэнд төмрийн хүдрийн үнэ 15.3 хувиар огцом унаж 78.3 ам.долларт хүрчээ. Нөгөө талд төмрийн хүдрийн нийлүүлэлт, тээвэрлэлтийн асуудал болон Хятад улсад вирусийн тархалт намжиж, гангийн болон бусад үйлдвэрийн үйл ажиллагаа дахин сэргэсэнтэй зэрэгцэн төмрийн хүдрийн үнэ эргэж өсөн эхний улирлыг дуустал 90 орчим ам.долларт хэлбэлзэж байв. Харин сүүлийн 7 хоногийн хугацаанд төмрийн хүдрийн үнэ 10 хувиар буурч 82 ам.долларт хүрэв.

Нүүрсний үнэ. Манай улс 2 сард зогсоогоод байсан нүүрсний экспортыг өнгөрсөн долоон хоногт нээж эхэлснээр Замын-Үүд, Шивээхүрэн, Гашуунсухайт, Ханги зэрэг дөрвөн боомтоор нүүрс тээвэрлэж байна. Цагаан сарын өмнө нэг тонн нүүрсний үнэ 830 юань байсан бол 4 сар гарснаас хойш 900 орчим юань дээр тогтсон байна.